



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/126

Сангиндалай

Хүүхдийн ордны тохижилт хийх
гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2 дахь заалт, ТБОНӨХБАУХА тухай хуулийн 46.1.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралт “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1, 3 дугаар зүйлийн 3.4.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын хүүхдийн ордны тохижилт хийх ажлыг “Тэлмэн Нетворк ХХК”-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсүгэй.
2. Уг ажилтай холбогдон гарах зардал 442,307,614 (Дөрвөн зуун дөчин хоёр сая гурван зуун долоон мянга зургаан зуун арван дөрвөн) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Т.Энхбат)-д зөвшөөрсүгэй.
3. Уг ажилд холбоотой гарсан зардалд хяналт тавин ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Энхдэлгэр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ  О.БАЗАРРАГЧАА

482302251